



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Г Нэр дэвшүүлж, санал болгох тухай 7

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7.2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан төрийн албаны тусгай шалгалтын Комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны ажлын байрны сонгон шалгаруулалтын тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо авсан хавсралтад заасан нэр бүхий иргэдийг томилуулахаар нэр дэвшүүлж, томилох эрх бүхий этгээдэд санал болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлд ирүүлэхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (Д.Нарангуяа)-т даалгасугай.

ДАРГА

Ц.Эрдэмбилэг

Ц.ЭРДЭМБИЛЭГ